

**РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛСЭН
СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХЯНАЛТЫН НЭГДСЭН ТАЙЛАН**
Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль

Тайлангийн хамрах хугацаа: **2024.06.10-06.28**

2024.07.05-ны өдөр

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.22-т заасан чиг үүргийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт **119 телевиз, Улаанбаатар хотын 31 радиогийн хөтөлбөрт** хуульд заасан үзүүлэлтээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийж ажиллалаа. Радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн тайлан мэдээг сонгуулийн сурталчилгааны эхний болон 2 дахь 7 хоногоор тус тус гаргаж өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн.

Түүнчлэн тус хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь цагийг Зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Хуралдааны 129 дугаар тогтоолын хавсралтаар баталж, 6-р сарын 08-ны өдрийн 130 дугаар тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг”, “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг”-ийн дагуу нэвтрүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллав. МҮОНРТ-ийн нэвтрүүлсэн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хяналт, мониторингийн нэгдсэн тайланг тусад нь гаргаж, цахим хуудсаар мэдээлж байгаа болно.

Радио, телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн дүн мэдээг сонгуулийн сурталчилгааны 17 хоног болон сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш санал авах ажиллагаа дуусталх 2 хоногийн хугацаанд нийт 19 хоногоор (2024 оны 6-р сарын 10-28-ны өдрүүд) гаргаж, хяналтын нэгдсэн тайлан мэдээг үүгээр танилцуулж байна.

Энэ удаагийн сонгуулийн сурталчилгааны тухайд өмнөх 2020 оны сонгуулийн сурталчилгаатай харьцуулахад богино хэмжээний сурталчилгаа багатай, 15 минутдаа багтаасан сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг түлхүү нэвтрүүлснээс гадна иргэд, сонгогчдын мэдэх эрхийг хангах, сонгуульд оролцогч нам, эвслийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдийн үзэл бодол, байр суурийг таниулах үүднээс мэтгэлцээн зохион байгуулж, нэвтрүүлэх хандлага илүү байгаа нь бүртгэгдсэн. Тухайлбал, сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт **67 телевизээр 429 цагийн** сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна. Түүнчлэн МҮОНРТ-ээс гадна **6 телевизээр давталтын дугааруудын хамт 85 удаагийн нийт 128 цагийн** мэтгэлцээний нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлжээ.

Эдгээр мэтгэлцээний нэвтрүүлэгт 17 нам, 2 эвсэл, бие даан нэр дэвшигч зэрэг давхардсан тоогоор нийт 204 нэр дэвшигч оролцсон байна.

Улаанбаатар хотын нийт 41 телевизээр нэвтрүүлсэн **296:44:11 цагийн сонгуулийн сурталчилгаанд 292:51:15 цагийн сурталчилгааны нэвтрүүлэг** эзэлж байгаа бол үүнээс дохионы хэлтэй нэвтрүүлэг **263:05:42 цаг**, бичгэн тайлбартай нэвтрүүлэг **20:37:35 цаг** нэвтрүүлсэн байна. Харин дээрх 292 цагийн сурталчилгаанд сонгуулийн богино хэмжээний сурталчилгаа - шторк **3:52:56 цаг эзэлжээ**. Үүнээс харахад нам, эвслүүд телевизүүдэд сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг өгөхдөө дохионы хэлтэй эсхүл хадмал тайлбартай бэлтгэх үүргээ хэрэгжүүлсэн байна.

Харин сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт **19** радиогоор нам, эвсэл, нэр дэвшигчдийн **8:38:11 цагийн сурталчилгааны нэвтрүүлэг**, **72:17:24 цагийн сурталчилгааны шторк**, нийт **80:55:35 цагийн сонгуулийн сурталчилгаа** нэвтрүүлсэн байна. Радиогийн тухайд богино хэмжээний сурталчилгааны шторк түлхүү нэвтрүүлжээ.

Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ хуулиар тогтоосон нэг хоногт нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны 60 минут, нам, эвсэл нэр дэвшигчийн сурталчилгааг 1 хоногт 15 минутаас хэтрүүлэхгүй байх, нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлэхгүй байх зэрэг хуулиар тогтоосон журмыг баримтлан хууль тогтоомжийг дээдлэн ажиллалаа.

РАДИО, ТЕЛЕВИЗҮҮДЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Хүснэгт 1. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн телевизийн тоо

Тусгай зөвшөөрлийн ангилал	Тусгай зөвшөөрлийн тоо/	Сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизүүд	Сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевиз							
	Хяналтад тоо		Эхний 7 хоног (06.10-16)	2 дахь 7 хоног (06.17-23)	6.24	6.25	6.26	6.27	6.28	Нийт
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18/18	17	17	17	17	17	17	0	0	17
Арилжааны телевиз	53/50	24	18	18	16	16	16	0	0	16
Орон нутгийн телевиз	48/41¹	42	28	32	27	28	28	0	0	28
Радио -УБ	31/31	24	18	19	18	18	15	0	0	18
Радио - Орон нутаг	25/24	18	Бичлэгээр							
	175*	125	84	Нийт сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизийн тоо						79
				67 ТВ, 19 радио						

*МҮОНРТ-ийн Телевизийн 5 суваг, радиогийн 4 суваг дээрх тоонд ороогүй хэдий ч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үзүүлэлтээр мөн хяналт тавьж байна.

Сонгуулийн сурталчилгааны нийт хугацаанд бүртгүүлсэн эрх бүхий **83** телевиз, **24** радиогоос нийт **67** телевиз, **19** радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн бөгөөд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн эрх бүхий **16** телевиз, **5** радио сурталчилгаа нэвтрүүлээгүй байна.

¹ Хардаар 4 ТВ-н бичлэг ирж хянагдсан, 1 ТВ-н (Орхон аймгийн Тэнгэр тв) эфир техникийн шалтгаанаар түр зогссон. 6 ТВ сурталчилгаа нэвтрүүлэхгүй үйл ажиллагаа зогссон.

Орон нутгийн радиогийн хувьд: Орон нутагт сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй 18 радио, сурталчилгаа нэвтрүүлэхгүй 1 радио нийт 19 радиогоос 2024 оны 06-р сарын 10-28-ны өдрүүдийн эфирийн бичлэгийг DVD-д буулган хүлээн авсан.

1. Сурталчилгаа нэвтрүүлэх эрхгүй радио, телевизээр сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх:

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10-т “Энэ хуулийн 46.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэхийг хориглоно” гэж заасан байдаг.

Гэвч сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хуульд заасан хугацаанд ирүүлж бүртгүүлээгүй буюу сонгуулийн сурталчилгаа явуулах эрхгүй 1 арилжааны телевизээр 2024 оны 06-р сарын 14-ний өдөр 17:03:35 цагаас 17:06:04 цагийн хооронд нийт **00:02:29 минутын сонгуулийн сурталчилгааны хэсгийг нэг удаа** нэвтрүүлсэн байгаа нь хяналт, мониторинг-д бүртгэгдсэн.

Иймд Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй Буган соёл ХХК-ийн “Хөх монгол” телевизэд дээрх хуулийн 46.24-т заасны дагуу албан бичгээр Сануулах арга хэмжээ авсан.

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхгүй Улаанбаатар хот болон орон нутгийн радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн өөр зөрчил сонгуулийн сурталчилгааны хугацаанд бүртгэгдээгүй байна.

2. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизийн тухайд:

- Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт **67** телевизээр нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах **408:16:18** цагийн сурталчилгааны нэвтрүүлэг, **20:54:17** цагийн сурталчилгааны шторк, нийт **429:10:35** цагийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 2. Телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг

№	Он сар өдөр	ТВ-ийн тоо	Нэвтрүүлэг (цагаар)	Реклам (цагаар)	Нийт (цагаар)
1	2024.06.10	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	17:28:04	0:02:29	17:30:33
		8 Орон нутгийн ТВ	1:18:52	0:32:31	1:51:23
2	2024.06.11	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	15:11:51	0:02:51	15:14:42
		17 Орон нутгийн ТВ	3:16:14	0:43:05	3:59:19
3	2024.06.12	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	15:47:58	0:06:35	15:54:33
		22 Орон нутгийн ТВ	5:09:47	0:37:56	5:47:43
4	2024.06.13	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	16:15:17	0:10:24	16:25:41
		18 Орон нутгийн ТВ	4:20:36	0:37:51	4:58:27
5	2024.06.14	33 (17 ӨНТВ, 16 АрТВ)	9:02:27	0:10:01	9:12:28
		23 Орон нутгийн ТВ	5:39:11	0:38:59	6:18:10
6	2024.06.15	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	12:13:44	0:09:57	12:23:41

		22 Орон нутгийн ТВ	5:42:32	0:44:08	6:26:40
7	2024.06.16	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	21:52:02	0:07:50	21:59:52
		22 Орон нутгийн ТВ	5:05:25	0:35:26	5:40:51
8	2024.06.17	33 (17 ӨНТВ, 16 АрТВ)	16:23:11	0:13:54	16:37:05
		25 Орон нутгийн ТВ	7:53:31	1:03:21	8:56:52
9	2024.06.18	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	15:46:11	0:11:52	15:58:03
		26 Орон нутгийн ТВ	7:59:33	0:49:39	8:49:12
10	2024.06.19	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	15:47:44	0:10:01	15:57:45
		27 Орон нутгийн ТВ	8:36:37	0:55:58	9:32:35
11	2024.06.20	33 (17 ӨНТВ, 16 АрТВ)	18:06:19	0:06:01	18:12:20
		26 Орон нутгийн ТВ	8:04:16	1:23:10	9:27:26
12	2024.06.21	34 (17 ӨНТВ, 16 АрТВ)	22:11:21	0:08:25	22:19:46
		23 Орон нутгийн ТВ	6:42:07	1:08:22	7:50:29
13	2024.06.22	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	18:08:21	0:20:36	18:28:57
		26 Орон нутгийн ТВ	8:02:34	1:39:38	9:42:12
14	2024.06.23	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	18:42:19	0:15:52	18:58:11
		26 Орон нутгийн ТВ	7:52:39	1:43:55	9:36:34
15	2024.06.24	37 (17 ӨНТВ, 16 АрТВ)	19:13:57	0:24:13	19:38:10
		26 Орон нутгийн ТВ	9:24:18	1:34:08	10:58:26
16	2024.06.25	38 (17 ӨНТВ, 16 АрТВ)	19:28:01	0:27:27	19:55:28
		27 Орон нутгийн ТВ	9:07:41	1:19:34	10:27:15
17	2024.06.26	39 (17 ӨНТВ, 16 АрТВ)	21:12:28	0:44:28	21:56:56
		28 Орон нутгийн ТВ	11:09:10	0:53:40	12:02:50
Нийт 1-р 7 хоногт			138:24:00	5:20:03	143:44:03
Нийт 2-р 7 хоногт			318:40:43	15:30:47	334:11:30
Нийт хугацаанд			408:16:18	20:54:17	429:10:35

График 1. Нийт телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг



Телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааг төрлөөр нь авч үзэхэд 95.23 хувийг сурталчилгааны нэвтрүүлэг, 4.87 хувийг реклам тус тус эзэлж байна.

Телевизүүдээр сонгуулийн сурталчилгаа (шторк), сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал

График 2. УБ хот. Телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн цаг





График 3. УБ хотын телевизүүдээр сонгуулийн сурталчилгааны реклам нэвтрүүлсэн байдал



Телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн нэгдсэн дүнгээс харахад нам, эвслүүдээс сонгуулийн богино хэмжээний сурталчилгаа буюу реклам бага, харин сурталчилгааны хоногийн 15 минутдаа багтаасан сурталчилгааны нэвтрүүлгүүд илүү их нийлүүлсэн нь харагдаж байна.

Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг дохионы хэл, бичгэн тайлбартай нэвтрүүлсэн байдал

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.27-д Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байна гэж заасан байдаг.

Иймд Харилцаа холбооны зохицуулах хорооноос сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторинг хийхдээ сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлэг, сонгогчдын боловсролын нэвтрүүлгийг дохионы хэл, бичгэн тайлбартай гаргаж байгаа эсэхийг бүртгэж тайланд тусгаж байгаа болно.

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлэг	Хадмал тайлбартай нэвтрүүлэг	№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлэг	Хадмал тайлбартай нэвтрүүлэг
1	25-р суваг	10:02:47	0:14:16	18	Мянгат Малчин ТВ	3:26:04	0:14:22
2	C1	11:20:44	0:59:31	19	ОНТВ	3:58:56	0:29:13
3	Channel 11	3:09:24	0:04:04	20	Өлзий ТВ	8:08:24	0:14:57
4	MNB	33:27:21	5:20:17	21	Парламент	5:22:27	0:14:15
5	MNC	7:44:20	0:14:16	22	Соён гэгээрүүлэгч	0:30:17	0:00:00
6	National times news	1:59:24	0:14:57	23	Стар ТВ	7:38:51	0:14:15
7	NTV	8:21:14	0:29:12	24	Суваг 1	5:17:31	0:29:14
8	SBN	12:12:46	0:58:32	25	Сүлд	11:08:13	0:25:00
9	ТМ	6:24:42	0:34:37	26	Талын Монгол	3:57:02	0:14:16
10	UBS	10:20:04	0:43:59	27	ТВ2	3:42:11	0:14:14

11	Авто ТВ	2:39:13	0:00:00	28	ТВ5	10:45:16	0:29:13
12	Боловсрол суваг	10:53:55	0:35:17	29	ТВ6	2:42:54	0:42:44
13	ЕТВ	12:01:00	0:59:11	30	ТВ8	12:45:49	2:08:58
14	Ийгл ньус	12:03:03	0:29:14	31	ТВ9	5:31:54	0:22:56
15	Лайв ТВ	8:07:12	0:58:45	32	Тэнгэр ТВ	14:19:13	0:23:02
16	Малчин ТВ	8:39:07	0:00:00	33	Хөгжил ТВ	0:14:58	0:44:48
17	Монгол HD	4:09:26	0:00:00		НИЙТ	263:05:42	20:37:35

Харин сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг дохионы хэл болон бичгэн тайлбартай байдлаар хамтад нь 20 телевизээр 8 цаг 8 минут нэвтрүүлсэн байна.


Сонгуулийн богино хэмжээний сурталчилгааг дохионы хэлтэй бус бичгэн тайлбартай нийлүүлсэн байна.

Сурталчилгааны шторк		
	Сек	Цаг:мин:сек
25-р суваг	86	0:01:26
С1	0	0:00:00
Central ТВ	0	0:00:00
ТМ	0	0:00:00
UBS	53	0:00:53
Боловсрол суваг	90	0:01:30
Гандан ТВ	848	0:14:08
Ийгл ньус	0	0:00:00
Малчин ТВ	0	0:00:00
Мянгат Малчин ТВ	0	0:00:00
Соён гэгээрүүлэгч	456	0:07:36
Суваг 1	0	0:00:00
ТВ5	0	0:00:00
ТВ9	2156	0:35:56
Нийт цаг		1:01:29

Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг нам, эвслээр нь гаргавал

Намаар	Дохионы хэлтэй нэвтрүүлэг	Хадмал тайлбартай нэвтрүүлэг
Ард түмний хүч нам	0:00:00	0:13:24
Ардчилал шинэчлэлийн нам	0:14:56	0:00:00
Ардчилсан нам	102:49:42	4:43:56
Бие даагч	0:27:20	0:12:26
Бүгд Найрамдах Нам	0:00:00	0:16:20
Иргэний зориг ногоон нам	6:34:38	2:39:37
Иргэний хөдөлгөөний нам	0:14:22	0:00:00
Монгол ардын нам	88:22:30	0:00:00
Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам	0:00:00	3:59:02
Үндэсний эвсэл	43:38:43	0:00:00
Үнэн ба Зөв нам	5:25:48	0:00:00
Хөдөлмөрийн үндэсний нам	13:58:36	0:12:58
Шинэ Нэгдсэн эвсэл	0:29:08	0:14:24
Эх орон нам	0:49:59	0:00:00

График 3. Орон нутгийн телевизүүдээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал



Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа радиогоор нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаа

- Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт **19** радиогоор нам, эвсэл, нэр дэвшигчдийн **8:38:11** цагийн сурталчилгааны нэвтрүүлэг, **72:17:24** цагийн сурталчилгааны шторк, нийт **80:55:35** цагийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 3. Радиогоор нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг.

№	Сурталчилгаа нэвтрүүлсэн өдөр	Радиогийн тоо	Нэвтрүүлэг (цагаар)	Реклам (цагаар)	Нийт (цагаар)
1	2024.06.10	7	2:08:15	0:03:02	2:11:17
2	2024.06.11	7	0:00:00	1:59:16	1:59:16
3	2024.06.12	8	0:00:00	3:10:51	3:10:51
4	2024.06.13	7	0:54:54	2:15:56	3:10:50
5	2024.06.14	8	0:00:00	3:07:54	3:07:54
6	2024.06.15	13	0:51:03	4:04:18	4:55:21
7	2024.06.16	18	0:44:50	5:56:50	6:41:40
8	2024.06.17	19	0:48:15	4:51:01	5:39:16
9	2024.06.18	18	0:45:49	5:06:41	5:52:30
10	2024.06.19	17	0:30:38	5:11:48	5:42:26
11	2024.06.20	17	0:42:38	4:46:08	5:28:46
12	2024.06.21	16	0:11:46	4:49:31	5:01:17
13	2024.06.22	17	0:18:15	4:54:12	5:12:27
14	2024.06.23	16	0:18:07	4:31:11	4:49:18
15	2024.06.24	18	0:00:00	5:55:32	5:55:32
16	2024.06.25	18	0:11:53	6:53:41	7:05:34
17	2024.06.26	15	0:11:48	4:39:32	4:51:20
Нийт (1-р 7 хоногт)			4:39:02	20:38:07	25:17:09
Нийт (2-р 7 хоногт)			3:35:28	54:48:39	63:03:09
Нийт сурталчилгааны хугацаанд			8:38:11	72:17:24	80:55:35



Улаанбаатар хотын радиогоор нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны **11** хувийг нэвтрүүлэг, **89** хувийг сурталчилгааны реклам (шторк) тус тус эзэлсэн байна.

3. Мэдээ, мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ нэвтрүүлсэн байдал

Телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар нэвтрүүлсэн мэдээг Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46.14-т заасны дагуу сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамааруулж тооцохгүй бөгөөд нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг 5 минутаас хэтрүүлэхгүй байх заалтыг зөрчсөн эсэх асуудлыг Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.19-т заасны дагуу гомдлоор шийдвэрлэнэ гэж заасан.

Зохицуулах хорооны зүгээс дээрх хуулийн 46.24-т заасны дагуу энэхүү хуульд заасан зөрчил гаргуулахгүй байх, гарсан зөрчлийг зогсоох арга хэмжээ авах чиг үүргийн дагуу радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингоор нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн хэтрэлт бүртгэгдсэн эсэхийг хянаж, хэрэв хэтрэлт гарсан тохиолдолд анхааруулж, зөвлөмж өгөх чиглэлээр ажиллахыг зорьсон бөгөөд мэдээний бүртгэлийн талаар тайлан мэдээндээ тусгаж ажилласан.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлэхгүй байх хуулийн хэрэгжилтийн байдлыг авч үзэхэд сурталчилгааны нийт хугацаанд радио, телевизүүд хуулийг хэрэгжүүлж, хуульд заасан 5 минутын хугацааг мөрдөж ажиллалаа. Нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээний хоногт гарах 5 минутын хэтрэлт 4 телевизэд бүртгэгдсэний дагуу анхааруулж, зөвлөмж өгч ажилласан.

Хүснэгт 4. Телевизээр нэвтрүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээний цаг

№	Огноо	Телевизийн тоо	Нийт (цаг)	Мэдээний нэвтрүүлэгт гарсан	
				Нам, эвслийн тоо	Бие даагчдын тоо
1	2024.06.10	УБ хотын 25 ТВ	4:12:18	8	2
		Орон нутгийн 6 ТВ	1:06:50	4	1
2	2024.06.11	УБ хотын 26 ТВ	4:27:51	9	0
		Орон нутгийн 12 ТВ	1:43:06	7	1
3	2024.06.12	УБ хотын 27 ТВ	4:52:28	9	1
		Орон нутгийн 11 ТВ	1:07:33	4	0
4	2024.06.13	УБ хотын 24 ТВ	8:10:21	13	0
		Орон нутгийн 13 ТВ	1:55:35	5	0
5	2024.06.14	УБ хотын 26 ТВ	6:24:10	11	0
		Орон нутгийн 11 ТВ	1:23:56	4	0
6	2024.06.15	УБ хотын 24 ТВ	3:37:35	12	1
		Орон нутгийн 8 ТВ	1:35:08	4	1
7	2024.06.16	УБ хотын 20 ТВ	3:24:17	10	1
		Орон нутгийн 6 ТВ	1:11:07	4	0
8	2024.06.17	УБ хотын 24 ТВ	6:53:29	11	1
		Орон нутгийн 13 ТВ	01:22:49	4	0

9	2024.06.18	УБ хотын 23 ТВ	9:16:51	12	1
		Орон нутгийн 11 ТВ	2:04:13	4	0
10	2024.06.19	УБ хотын 24 ТВ	12:24:34	11	2
		Орон нутгийн 14 ТВ	02:44:45	5	0
11	2024.06.20	УБ хотын 26 ТВ	9:03:16	10	1
		Орон нутгийн 13 ТВ	2:30:07	6	0
12	2024.06.21	УБ хотын 26 ТВ	7:00:31	9	1
		Орон нутгийн 12 ТВ	00:45:05	4	0
13	2024.06.22	УБ хотын 22 ТВ	7:33:35	12	1
		Орон нутгийн 10 ТВ	0:44:30	4	0
14	2024.06.23	УБ хотын 24 ТВ	8:09:35	11	1
		Орон нутгийн 6 ТВ	00:24:55	2	0
15	2024.06.24	УБ хотын 24 ТВ	8:45:52	11	3
		Орон нутгийн 13 ТВ	0:43:31	4	0
16	2024.06.25	УБ хотын 24 ТВ	6:54:39	9	2
		Орон нутгийн 7 ТВ	0:20:19	2	0
17	2024.06.26	УБ хотын 26 ТВ	10:04:58	10	3
		Орон нутгийн 10 ТВ	0:45:25	4	0
Нийт			143:45:14	249	24

4. Радио, телевизүүдийн хөтөлбөрт хуульд заасан зөрчил бүртгэгдсэн эсэх:

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛСЭН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ДҮН.

Мониторингд хамрагдсан хугацаа: 2024.06.10-2024.06.28

Хүснэгт 5. Сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн нэгдсэн дүн

№	Хяналт тавьсан үзүүлэлт	Улаанбаатар			Орон нутаг
		06 дугаар сарын 10-26-ны өдрүүдэд			
		ӨН Телевиз	Арилжааны Телевиз	Радио	Телевиз
1	Эх сурвалжийг дурдаагүй сонгуулийн сурталчилгаа (Хуулийн 39.4) (Сонгуулийн сурталчилгаа гэдэг нь тодорхой боловч нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг нэвтрүүлгийн туршид байршуулаагүй)	-	-	-	2 ТВ
2	Сурталчилгааг хоногт 1 цаг /60 минут/-аас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 46.6)	1ТВ	-	-	1ТВ
3	Нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сурталчилгааны хугацаа хоногт 15 минутаас хэтэрсэн эсэх: (Хуулийн 46.7)	-	1 ТВ	5 радио	6ТВ
4	Мэдээ: Нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 46.14)	-	3 ТВ	-	1 ТВ

5	Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зааснаас бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлсэн эсэх (Хуулийн 48.10)	1* ТВ	8* ТВ	17* радио (Дуу)	6* ТВ
6	Сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаанд намын тэмдэг, уриа, далбаа, дүрс бичлэг, яриа орсон бол 4.2.3	1 ТВ	9 ТВ	-	7 ТВ
7	Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх. (Хуулийн 46.28)	-	-	-	-

* Эцсийн тайланд хуулийн 48.10 дахь заалтын зөрчлөөр бүртгэгдсэн нийт 15 телевиз нь нам эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон бие даасан нэвтрүүлэг нэвтрүүлсэн телевизүүд бөгөөд тухайн нэвтрүүлгийг гаргасан талаар анхааруулж сануулснаас хойш дахин эфирт гаргаагүй, зөрчил давтагдаагүй байна. Тухайн нэвтрүүлгүүд нь бүгд сонгуулийн сурталчилгаанаас өмнө хийгдсэн нэвтрүүлгүүд байв.

- Харин нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн дүрс, зураг орсон, ажил үүргийн хүрээнд богино ярилцлага өгсөн зэрэг нэвтрүүлэг болон дуулсан дууг нь нэвтрүүлсэн нийт 17 телевиз бүртгэгдсэн байна. Эдгээр телевизүүдийн тухайд нэр дэвшигч оролцсон бие даасан нэвтрүүлэг биш гэж үзэж, дээрх журмын 4.2.3-т хамааруулж тусад нь бүртгэв.
- Түүнчлэн нийгмийн хариуцлагын хүрээнд сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн “Хүнсний хувьсгал” нэвтрүүлгийн зарим дугаарыг Улаанбаатар хотын арилжааны 10 ТВ, орон нутгийн 5 ТВ нэвтрүүлсэн нь нэр дэвшигчдийн дүрс бичлэг, яриа орсон тул мониторингд бүртгэгдэж ирснийг тухай бүр телевизүүдэд сануулснаар дахин нэвтрүүлээгүй байна.
- *Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд 17 радиогоор С.Жавхлан, Х.Батмэнд, М.Нарантуяа (Нара), Ж.Баясгалан, Д.Баясгалан, Ш.Бат-Эрдэнэ, Т.Бат-Оргил нарын 7 нэр дэвшигчийн дуулсан дууг нэвтрүүлсэн. Хамгийн олон нэвтрүүлсэн дууны тухайд 2-р тойрогт нэр дэвшсэн С.Жавхлан, 5-р тойрогт Шинэ нэгдсэн эвслээс нэр дэвшигч Ш.Бат-Эрдэнэ, Д.Баясгалан нарын дуу байв.

Сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр гаргасан нэгдсэн дүн мэдээ

1. МУИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 39.4. Сонгуулийн сурталчилгаа гэдэг нь тодорхой боловч нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг нэвтрүүлгийн туршид байршуулаагүй зөрчил.

Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичээгүй, эх сурвалжийг дурдаагүй сурталчилгааны нэвтрүүлэг гаргасан зөрчил орон нутгийн 2 телевизэд бүртгэгдсэн.

Хүснэгт 6. Сурталчилгааны эх сурвалж дурдаагүй буюу сурталчилгааны хугацаанд захиалагч нам, эвсэл, нэр дэвшигчийг тодорхой гаргаагүй сурталчилгаа бүртгэгдсэн байдал:

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн ТВ тоо	Телевизийн нэр	Тайлбар
1	06-р сарын 23-ны өдөр	Орон нутгийн 2 ТВ	Дорнод-Мижи ТВ, Налайх- Буян ТВ	Иргэний зориг ногоон намын Хэнийг дугуйлах вэ? Сурталчилгааны нэвтрүүлэг, МАН-ын Ачаа тэнцүүлсэн алба, Монгол улсын засгийн газрын ажил тоон хэлээр сурталчилгааны нэвтрүүлэг- Аль нам, эвслийн сонгуулийн сурталчилгаа гэдэг нь тодорхой, ойлгомжтой байсан тул сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах 15 минутад оруулж тооцоход хуульд заасан хугацаа хэтрээгүй.

Авсан арга хэмжээ: Тухайн 2 телевизэд захиалагч нам, эвслийн нэрийг нэвтрүүлгийн туршид байршуулах талаар анхааруулсан.

2. МУИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 46.6.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны нийт хугацааны хяналт, мониторингийн дүн, мэдээгээр сонгуулийн сурталчилгааг хоногт **1 цаг /60 минут/-** аас хэтрүүлсэн зөрчил 2 телевизэд тус бүр 1 удаа бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7. Сурталчилгааны 60 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал:

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн ТВ тоо	Хэтрэлт бүртгэгдсэн телевиз	Тайлбар
1	06-р сарын 26-ны өдөр	2 ТВ	УБ-ӨНТВ- ТВ9 телевиз, Ховдын- Олон ястны ТВ	ТВ9 телевиз нь Сонгуулийн сурталчилгааны хоногт нэвтрүүлсэн нийт хугацааг авч үзэхэд хуулийн 46.6-д заасан хугацааг 2 минут 41 секунд хэтрүүлсэн байна. Ховд аймгийн Олон ястны ТВ нь МАН-аас нэр дэвшигч М.Мэндсайханы 4 минутын сурталчилгааг 26 удаа давтсан. Тус телевизээс маргааш өдөр нь алдаа гарсныг мэдэгдэж, албан бичиг ирүүлсэн. Албан бичигт эфир хариуцсан хүн эрүүл мэндийн шалтгаанаар эмнэлэг явах хооронд эфирт алдаа гарсан, алдааг мэдсэн даруйд эфирээ зогсоосон талаар дурдсан байна.

Авсан арга хэмжээ: ТВ9 телевиз болон Олон ястны телевизэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.24-т заасны дагуу Сануулах арга хэмжээ авсан.

3. Нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сурталчилгааг хоногт гарах 15 минутын хэтрэлт бүртгэгдсэн мэдээлэл:

Хүснэгт 8. Телевизээр нэвтрүүлсэн сурталчилгааны 15 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн ТВ тоо	Хэтрэлт бүртгэгдсэн телевиз	Тайлбар
---	-------	----------------------------------	-----------------------------------	---------

1	06-р сарын 10, 14-ний өдөр	1 ТВ	Завхан аймгийн Air 1	6-р сарын 10-ны өдөр Ардчилсан намаас нэр дэвшигч Ш.Адьяа оролцсон нэвтрүүлгийг давтсан мөн сурталчилгааны нэвтрүүлгээс гадна сурталчилгааны 22 шторк нэвтрүүлсэн нь нийтдээ 1625 секунд хэтэрсэн байна. 6-р сарын 14-ний өдөр Ардчиллын цаг нэвтрүүлгийн хэсгийг давтсанаар 193 секунд хэтрүүлсэн.
2	06-р сарын 19-ний өдөр	Орон нутгийн 1 ТВ	Дархан-Уул ТВ4	"Алдагдсан 8 жилийн алдааг засна" нэвтрүүлгийг давтан гаргаснаар 854 секундйн хэтрэлт бүртгэгдсэн.
3	06-р сарын 22-ны өдөр	3 ТВ	Ховд- Жаргалант, Ховд ТВ, УБ- Мянгат малчин ТВ	Сурталчилгааны шторкуудыг давталттай гаргасан нь хэтрэлт болсон.
4	06-р сарын 23-ны өдөр	Орон нутгийн 1 ТВ	Ховд- Жаргалант	Сурталчилгааны шторкуудыг давталттай гаргасан нь хэтрэлт болсон.
5	06-р сарын 24-ний өдөр	Орон нутаг 2 ТВ	Дархан-DBS телевиз, Сүхбаатар- SB телевиз	DBS- 157 сек, SB ТВ 131 секундээр хэтэрсэн
Нийт УБ -Арилжааны 1 ТВ, орон нутгийн 6 ТВ				

Авсан арга хэмжээ. Дээрх Air1, ТВ4, Жаргалант, DBS, SB телевизүүдэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.24-т заасны дагуу Сануулах арга хэмжээ авсан. Зөрчил дахин давтагдаагүй.

Хүснэгт 9. Радиогоор нэвтрүүлсэн нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сурталчилгааны хоногт гарах 15 минутаас хэтрүүлсэн бүртгэл

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн радио тоо	Хэтрэлт бүртгэгдсэн радио	Тайлбар
1	06-р сарын 19 ний өдөр	2 радио	ФМ 101.7, 104.5	ФМ101.7 - 41 сек, ФМ 104.5 -159 сек сурталчилгааны хугацааг хэтрүүлсэн.
2	06-р сарын 20- ны өдөр	3 радио	ФМ 101.7, ФМ107.5, ФМ 96.3,	Хоногт 15 минутаас хэтрүүлсэн . ФМ 101.7- 140 сек, ФМ 107.5-157 сек, ФМ96.3-81 сек. Тус бүр нэг удаа.
3	06-р сарын 21- 22 ны өдөр	2 радио	ФМ96.3, ФМ 107.5	ФМ 96.3- 153 сек, ФМ 107.5-97 сек.Тус бүр нэг удаа.
4	06-р сарын 23 ны өдөр	1 радио	ФМ96.3	ФМ96.3- 171 секундын хэтрэлт
5	06-р сарын 25,26- ны өдөр	1	ФМ 92.5,	ФМ 92.5-149,6 сек
Нийт 5 радио				

Авсан арга хэмжээ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.24-т заасны дагуу ФМ 101.7, ФМ 96.3, ФМ 92.5 радиод Сануулах арга хэмжээ авсан. Зөрчил дахин давтагдаагүй.

4. Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээний хоногт гарах 5 минутын хэтрэлтийн талаарх мэдээлэл:

Хүснэгт 10. Мэдээний 5 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал.

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн тоо	Хэтрэлт бүртгэгдсэн радио, телевиз	Тайлбар м
1	06-р сарын 10	УБ- 2 ТВ	Айст Глобал ТВ,News Channel	35 мин,7 мин
2	06-р сарын 14, 15-ны өдөр	УБ-1 ТВ, Орон нутгийн 1 ТВ	MNC, ТВ4	5 мин, 5 мин
3	06-р сарын 17, 21-ний өдөр	Орон нутгийн 1 ТВ	Дархан-Уул ТВ4	1 мин болон 14мин
Бусад өдөр хэтрэлт бүртгэгдээгүй				
Нийт УБ хотын Арилжааны 3 ТВ, орон нутгийн 1 ТВ				

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа радиогийн хувьд хэтрэлт бүртгэгдээгүй.

Авсан арга хэмжээ: Нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлэхгүй байх Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46.14 дэх заалтыг зөрчсөн эсэх асуудлыг Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.19-т заасны дагуу гомдлоор шийдвэрлэнэ гэж заасан тул хяналт, мониторингоор мэдээний хэтрэлт илэрсэн дээрх 4 телевизэд анхааруулж, зөвлөмж өгч ажилласан.

- Сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээний хоногт гарах 5 минуттай холбоотой гомдол ирээгүй байна.

5. Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлага нэвтрүүлсэн эсэх:

- Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглосон. (Хуулийн 48.10)

5.1. Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг бүртгэгдсэн.

Хүснэгт 10. Телевизүүдээр нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлгийн бүртгэл:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Телевизийн нэр	Нэвтрүүлгийн тайлбар
Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдээс:			
1	Алсын гэрэл ХХК	TM	Шинжлэх ухааны нийтлэл, нэр дэвшигч Норовын Тэгшбаярын торолцсон нэвтрүүлэг
2	Хатрек ХХК	Eco Channel	Эко хэмнэл өдрийн хөтөлбөр. Я. Батхүү нэр дэвшигч оролцсон бие даасан нэвтрүүлэг
3	Монголиан ньюс чаннел ХХК	MNC	Ярилцах цаг. Н.Баттогтох, Р.Булгамаа нэр дэвшигчид оролцсон
4	Малчин телевиз ХХК	Мянгат Malchin	Монголын баялаг 330 Д.Бум-Очир нэр дэвшигч оролцсон бие даасан нэвтрүүлэг
5	Масс Ти Ви ХХК	Масс ТВ	“Хүүхэд 1 дүгээрт хөтөлбөр”. Бие даасан нэвтрүүлэг Я.Батхүү нэр дэвшигч оролцсон.
6	Монгол телевиз ХХК	Монгол ТВ1+	“Заншлын хэлхээ”- танин мэдэхүйн нэвтрүүлэгт Д.Бум-Очир нэвтрүүлгийн туршид хөтөлж гарсан.
7	Энтертайнмент интэрпрайс ХХК	Бидний цөөхөн монголчууд	“Аян замын тэмдэглэл”, “Зоригтын цаг”, “Ахмадуудын цаг” Д.Өнөрболор нэр дэвшигч оролцсон.
8	Форчун глобал ХХК	Айст Глобал	Дулаахан намар тоглолт. С.Жавхлан
9	Хөгжил телевиз ХХК	Хөгжил телевиз	Монгол тулгатны зуун эрхэм, П.Анужин нэр дэвшигч
Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй телевизүүдээс:			
10	Дархан мэдээлэл төв ХХК	DBS ТВ	“Chinguns kids podcast” Хөгжмийн завсарлага Н.Амаржин нэр дэвшигч оролцсон
11	Дадишуар гоёл ХХК	DS ТВ	Чинээлэг малчин бойжуулах төв-Л.Одсэр нэр дэвшигч оролцсон
12	Фило ХХК	TV24	“Professional”, “Кофетой яриа” П.Наранбаяр нэр дэвшигч оролцсон, “Гэмшлийн гэрэлт зам” С.Одонтуяа нэр дэвшигч оролцсон
13	Хийморь ТВ ХХК	TV4	Tegshee's podcast нэвтрүүлэг, Шинжлэх ухааны нийтлэл.
14	Ишилан ХХК	EBS ТВ	“Шинэ танил” нэвтрүүлэг, Хөгжмийн завсарлага С.Жавхлан нэр дэвшигч дуулсан дуу
15	Асгатын гол ХХК	Мэдээллийн бирж ТВ	Үхэл бол цэг биш таслал- Д.Бум-Очир нэр дэвшигч гарсан, “Марс хол биш” баримтат кино

5.2. Радиоогоор нэр дэвшигчийн дуулсан дуу нэвтрүүлсэн бүртгэл

Хүснэгт11 . Радиоогоор нэр дэвшигчийн дуулсан дуу нэвтрүүлсэн бүртгэл

Огноо	Радиогийн тоо	Зөрчил бүртгэгдсэн радио	Дууны тайлбар
06-р сарын 17	5	ФМ 104.5, ФМ92.1, ФМ96.9, ФМ97.5, ФМ99.7	С.Жавхлан, Д.Баясгалан, дуу
06-р сарын 18	3	ФМ101.7, ФМ92.1 ФМ97.5	С.Жавхлан, Д.Баясгалан, Ш.Бат-Эрдэнэ дуу
06-р сарын 19	3	ФМ99.3, ФМ96.9, ФМ99.7	С.Жавхлан
06-р сарын 20	3	ФМ 92.1, ФМ 96.9, ФМ 99.7	Д.Баясгалан, Х.Батмэнд, С.Жавхлан
06-р сарын 21	5	ФМ 92.1, ФМ 96.9, ФМ 99.8, ФМ 99.7 ФМ99.3	Д.Баясгалан, Ш. Бат-Эрдэнэ, С.Жавхлан
06-р сарын 22	4	ФМ 101.7, ФМ 92.1, ФМ102.1, ФМ 99.3	С.Жавхлан, Ш.Бат-Эрдэнэ
06-р сарын 23	4	ФМ 92.1, ФМ102.1, ФМ 96.3, ФМ89.7	С.Жавхлан, Ш.Бат-Эрдэнэ М.Нарантуяа НАРА

Авсан арга хэмжээ: Сурталчилгааны хугацаанд дээрх радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд зөвхөн нэр дэвшигчдийн дуулсан дуу нэвтрүүлсэн нь бүртгэгдсэн. Нэр дэвшигчдийн нэр дэвшсэн тойргуудад хөтөлбөр нь цацагддаггүй тул утсаар анхааруулж, зөвлөмж өгч ажиллав. Харин нэр дэвшигчийн дууг давтан нэвтрүүлсэн 3 радиод Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.24-т заасны дагуу ФМ 95.7, ФМ 96.9, 102.1 радиод тус бүр Сануулах арга хэмжээ авсан.

6. Сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг дундуур нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн богино яриа орсон, ярилцлага өгсөн, эсхүл нэр дэвшигчдийн дүрс бичлэг, зураг орсон, нэр дэвшигчийн дуулсан дуу нэвтрүүлсэн телевизүүд.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэр	Телевизийн нэр	Нэвтрүүлгийн тайлбар
1	Суваг ти ви найм ХХК	TV8	Эфир эхлэхэд С.Жавхлангийн дуулсан төрийн дуулал гарсан.
2	Эх гоёот медиа групп ХХК	Channel11	Эфир эхлэхэд С.Жавхлангийн дуулсан төрийн дуулал гарсан.
3	Эс Си Эйч ХХК	Суваг 1	Сайхан дууны түүх. С.Жавхлан. М.Нарантуяагийн тоглосон УСКино
4	Ди Ви Продакшн ХХК	TV3	Монгол улсын их хурал- Зөвшөөрлийн тухай хууль батлав. Х. Булгантуяа, Х. Ганхуяг, П. Сайнзориг, Б. Энхбаяр нарын яриа орсон.
5	Хөгжил телевиз ХХК	Хөгжил телевиз	Нууц материалууд эрэн сурвалжлах нэвтрүүлэг, Zangia TV -
6	Маст технологи ХХК	News channel	Монгол уламжлал /News/ О.Билгүүний дүрс гарч 2 минут орчим ярисан
7	Найс ти ви ХХК	АВТО	Улс төрийн задлан,

8	Жи суваг ХХК	Гандан ТВ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 30 жил, Эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал, Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс үзүүлж байна. Монгол бахархал баримтат кино - С.Одонтуяа
9	Гэгээн далай ХХК	movie max	Мандалын хурд 2023. Ц. Мөнхбат
10	Форчун глобал ХХК	Айст Глобал	Дулаахан намар тоглолт. С.Жавхлан
Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй телевизүүдээс			
11	Сайхан Монгол ЭИАК ТББ	Сайхан Монгол ТВ	Хөгжмийн засварлага. С.Жавхлан
12	Шинэ зураг ХХК	Жаран ТВ	Хөгжмийн завсарлага. С.Жавхлан
13	Тамсаг мэнэнгийн тал ХХК	Талын анир ТВ	Дорнод баярын хурал шагнал гардуулах ёслолын ажиллагаа дээр М.Бадамсүрэн шагнал гардуулсан
14	Очир роуд ХХК	Тусгал 1 ТВ	Улаан шугам баримтат кино. Нэр дэвшигч шагнал гардуулсан Л. Оюун-Эрдэнэ, С. Энхболд
15	Өсөх прогресс ХХК	Хөвсгөл ТВ	Хань татаад байна, Г.Ганхуяг. Хөх сувд мөсний баяр 2023
16	Эхлэх шинэ жаргалант ХХК	Жаргалант ТВ	Улаан шугам Баримтат кино, Бөхийн барилдаан. С. Бямбацогт, Б.Пүрэвдорж
17	Ёл цуурай ХХК	UCTV	Боломж 2024 нэвтрүүлэг, нэр дэвшигч М.Ганхүлэг

Эдгээр нэвтрүүлгийг ихэнх телевизүүд сурталчилгааны эхний өдрүүдэд нэвтрүүлсэн бөгөөд тухайн телевизүүдэд анхааруулж, сануулсны дагуу дээрх нэвтрүүлгүүд дахин бүртгэгдээгүй байна.

Авсан арга хэмжээ.

- Энэхүү тайлангийн 5.1 дэх хэсэг- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 48.10 дахь заалтад заасан нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлсэн;
- 6 дах хэсэг- Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.2.3-т заасны сонгуулийн сурталчилгааны бус өмнө хийсэн нэвтрүүлэгт нэр дэвшигчдийн дуу, дүрс бичлэг, яриа орсон нэвтрүүлэг тус тус нэвтрүүлсэн дээрх телевизүүдэд зөвлөгөө анхааруулга өгсөн боловч давтан гаргасан дараах 6 телевизэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.24-т заасны дагуу Сануулах арга хэмжээ авч албан бичиг хүргүүлсэн. Үүнд: Жи суваг ХХК-ийн **Гандан ТВ**, Энтертайнмент энтерпрейс ХХК-ийн **Бидний цөөхөн монголчууд ТВ**, Маст технологи ХХК-ийн **News channel ТВ**, Хөгжил телевиз ХХК-ийн **Хөгжил ТВ**, Хийморь ТВ ХХК-ийн **ТВ4**, Эхлэх шинэ Жаргалант ХХК-ийн **Жаргалант ТВ** телевизүүдэд сануулах арга хэмжээ авсан албан бичиг хүргүүлсэн байна.

6.1. Нийгмийн хариуцлагын үүднээс гаргаж байсан өмнө хийсэн нэвтрүүлэг давтсанаас нэр дэвшигчийн яриа орсон нэвтрүүлэг бүртгэгдсэн:

Хүснэгт 11. Хүнсний хувьсгал нэвтрүүлэгт нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн нэр, дүрс орсон нэвтрүүлэг нэвтрүүлсэн телевизийн бүртгэл:

Улаанбаатар хотын арилжааны телевиз		
1	Эм Ди Энтертэймент ХХК	TV 2
2	Хатрек ХХК	Eco Channel
3	Монголиан ньюс чаннел ХХК	MNC
4	Дөрөв кэй мүүв ХХК	Талын Монгол
5	Эн Ти Эн Эйч Ди Медиа Групп ХХК	NTN
6	Ди Ви Продакшн ХХК	TV3
7	Маст технологи ХХК	News channel
8	Жи суваг ХХК	Гандан ТВ
9	Буган соёл ХХК	Хөх монгол
10	Форчун глобал ХХК	Айст Глобал
Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй телевизүүдээс		
1	Фило ХХК	TV24
2	Асгатын гол ХХК	Мэдээллийн бирж ТВ
3	Ёл цуурай ХХК	UCTV
4	Буян налайх ХХК	Буян ТВ
5	Эхлэх шинэ жаргалант ХХК	Жаргалант ТВ

Нийгмийн хариуцлагын хүрээнд өмнө хийгдсэн Хүнсний хувьсгал нэвтрүүлгийн дугааруудад нэр дэвшигчийн дүрс бичлэг, яриа орсон байгааг эхний удаа утсаар анхааруулан зөвлөгөө өгч ажилласан бөгөөд дээрх нэвтрүүлгүүд дахин бүртгэгдээгүй болно.

7. Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн зөрчил бүртгэгдээгүй.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ЯВЦАД ҮҮССЭН БОЛОН ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46.22, 48.12 дах хэсэгт заасан чиг үүргийн дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар МҮОНРТ-ээс бусад радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаанд хуульд заасан тодорхой хэмжигдэхүйц буюу энэхүү тайлангийн Хүснэгт 5-д заасан үзүүлэлтүүдээр радио, телевизүүдийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж, тайлан мэдээ гаргаж ажилласан.

Телевизүүдийн хөтөлбөрт дээрх үзүүлэлтүүдээр хяналт, мониторинг хийхдээ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 39.1,39.4, 46 дугаар зүйл, 46.10 дахь заалт мөн Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх бүртгэхээс татгалзах журамд заасныг баримтлан мониторинг хийсэн.

Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасан үзүүлэлтүүдээр хяналт, мониторинг хийх явцад дараах асуудлууд гарсныг цаашид анхаарч, холбогдох хууль тогтоомжид тодорхой тусгах эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал:

1. **Захиалагчийн нэрийг дурдаагүй буюу эх сурвалж тодорхойгүй дараах 2 төрлийн нэвтрүүлэг бүртгэгдсэн байна.** Үүнд:
 - Эх сурвалжийг буюу Захиалагчийг тодорхой дурдаагүй, төлбөрт, захиалгат шинжтэй нэвтрүүлэг боловч аль нэг нэр дэвшигчийн талаар ярьсан эсхүл нэр дэвшигчийн нэрийг дурдсан, нэр дэвшигчийн дүрс бичлэг орсон нэвтрүүлэг;

Эх сурвалж тодорхой дурдаагүй, төлбөрт, захиалгат гэсэн тэмдэглэгээгүй боловч нэр дэвшигчийн нэрийг дурдсан, нэр дэвшигчийн дүрс бичлэг орсон сонгуулийн сурталчилгааны бус 4 нэвтрүүлэг өргөн нэвтрүүлгийн 8 ТВ (SBN, NTV, Малчин, UBS, C1, TV5, ETV, TM), арилжааны 2 телевизээр (Өлзий ТВ, Масс ТВ) нэг нэг удаа 6-р сарын 12, 13, 14, 24, 26-ны өдрүүдэд нэвтрүүлсэн нь бүртгэгдсэн.

Дээрх 4 нэвтрүүлгийг тодотговол УИХ-ын гишүүн асан Г.Уянга нэр дэвшигч Н.Номтойбаярын нэрийг дурдаж, тайлбар хийх байдлаар ярьсан **13 минутын** нэвтрүүлэг, Ж.Баттуул сэтгүүлчийн Нэр дэвшигч Ч. Хүрэлбаатарын талаарх яриа, тайлбар бүхий нэвтрүүлэг-Нэвтрүүлгийн урт **00:17:45 сек урттай**, Ч.Содбилэг редакторын МОАХ дарга асан Б.Билэгтэй хийсэн ярилцлагын нэвтрүүлэг дундуур С.Эрдэнэ, Н.Алтанхуяг, Л.Оюун-Эрдэнэ, Чойжилсүрэн, Болормаа гм нэр дэвшигчдийн талаар ярьсан, **00:12:48 секунд**ийн нэвтрүүлэг, Ч.Содбилэг редактор ЦЕГ-ын дарга асан Ч.Амарболд генералтай 7 сарын 1-ний талаар ярьсан нэвтрүүлгийн дундуур Жаргалсайхан, Батзандан гм нэр дэвшигчдийн талаар ярьж, нэрийг дурдаж, дүрсийг гаргасан, нийт нэвтрүүлгийн **урт 00:15:00 секунд**.

- Эдгээр нэвтрүүлгийн тухайд эх сурвалж тодорхойгүй, сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэгт хамаарахаар боловч тухайн нэвтрүүлгийн дундуур нэр дэвшигчийн нэрийг дурдсан, дүрс бичлэг орсон байх тул Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.2.3¹-т заасны дагуу сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамааруулж, тухайн телевизийн хоногт гарах сонгуулийн сурталчилгааны хугацаанд нэмж тооцож байгаа талаар анхааруулж, сурталчилгааны хугацаанд аливаа төлбөрт, захиалгат нэвтрүүлэг нэвтрүүлэх бол эх сурвалжийг дурдаж, сурталчилгааны 15 минутдаа багтаан гаргахыг анхааруулсан.

Хэрэв сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг нь төлбөрт, захиалгат гэсэн тодотгол, тэмдэглэгээ байхгүй бол төлбөртэй, захиалгатай гэж хяналт, мониторингоор шууд тодорхойлж, дүгнэх боломжгүй байв.

Иймд цаашид төлбөртэй, захиалгатай гэсэн тэмдэглэгээ байхгүй, хэн нэгэн нам, эвсэл, эсхүл нэр дэвшигчид хамааруулсан нэвтрүүлгийг хэрхэн авч үзэх, мөн дээрх нэвтрүүлгийн адил нэр дэвшигчийн нэрийг дурдсан, дүрс бичлэг нь орсон бол нийт нэвтрүүлгийг сурталчилгааны хугацаанд авч үзэх, эсхүл зөвхөн тухайн нэр дэвшигчтэй холбоотой хэсгийг тооцох зэргийг тодорхой болгох шаардлагатай байна.

¹ Журмын 4.1-т ... энэ журмын 4.1-т заасныг хангаагүй, сонгуулийн сурталчилгаа гэдгийг тодорхой илэрхийлээгүй, захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй сонгуулийн сурталчилгааны болон сурталчилгааны бус дараах нэвтрүүлэг гарсан бол сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамааруулж тооцно. 4.2.1-н, нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй төлбөр, захиалгат нэвтрүүлэг, зар сурталчилгаа нэвтрүүлсэн бол; **4.2.3.** Сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаа зэрэгт нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрсний бичлэг, яриа нь орсон бол

1. Радиогоор нэр дэвшигч дуулсан дуу нэвтрүүлсэн бүртгэлийн талаар

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 48.10-т заасны дагуу радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглосон.

2020 оны сонгуулиас өмнө сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвслүүдээс өгсөн сурталчилгааны шинжтэй дуу нэвтрүүлэх, эсхүл дуулсан дуугаа сурталчилгааны хугацаанд гаргах, дууны клипэнд намын далбаа сурталчилгаа гэж ойлгогдохуйц байдлаар оруулах, клипэнд нэр дэвшигч орох зэрэг төрөл бүрийн хэлбэрийн дуу, клип гарч сурталчилгаанд авч үзэхэд хүндрэлтэй байсан бол дээрх хуулийн заалт болон журмаар тодорхой болгосны дүнд сурталчилгаа эхэлснээс хойш дээрх хэлбэрийн дуу нэвтрүүлэхийг хориглосон. Харин эдгээр төрлийг дууг аль, нам, эвсэл, нэр дэвшигчээс гэдэг тодорхой тэмдэглэгээ тавьж, сурталчилгааныхаа хугацаанд гаргах нь нээлттэй бөгөөд энэ удаагийн сонгуулиар нэр дэвшигч дуулсан дуу, орсон клипээ сурталчилгаандаа ашиглаж, сурталчилгаанд нь оруулж тооцсон тохиолдол мөн байгаа болно.

2024 оны сонгуулийн сурталчилгааны хугацаанд хэд хэдэн нэр дэвшигчдийн өмнөх нь дуулсан дуунуудыг фм радиогоор нэвтрүүлсэн тохиолдлууд нэлээд бүртгэгдсэн. Гэвч тухайн фм радио нь Улаанбаатар хотод хөтөлбөрөө цацдаг, дуу дуулсан нэр дэвшигчийн өрсөлдөж байгаа тойрог Улаанбаатар хотод хамаарахгүй тохиолдолд анхааруулж, зөвлөгөө өгч ажилласан. Харин давтагдсан тохиолдолд хуульд заасны дагуу дээр өгүүлсэн арга хэмжээ авч ажилласан. Иймд Улаанбаатар хот, эсхүл өөр нэг аймгийн радиогоор тухайн тойрогт хамааралгүй нэр дэвшигчийн дуу нэвтрүүлэхэд эрхзүйн үр дагавар ямар байх талаар анхаарч журамд тодорхой болговол хяналт, мониторингоор зөрчлөөр бүртгэх эсэхийг шийдвэрлэхэд мөн ач холбогдолтой юм.

МҮОНРТ-ээс БУСАД ТЕЛЕВИЗҮҮДЭЭР НЭВТРҮҮЛСЭН МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН


6 -р сарын 10-26 -ны өдрүүд

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд 25-р суваг, TenGer, Парламент, Соён гэгээрүүлэгч, ТВ8, ТВ9 телевиз гэсэн нийт 6 телевизээр мэтгэлцээний нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлжээ.

МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

№	Телевизийн нэр	Шинэ дугаар	Давталт	Нийт нэвтрүүлсэн цаг	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн байдал
1	TenGer	20	23	84 цаг 17 минут	Бүтэн
2	ТВ8	13	-	12 цаг 57 минут	Бүтэн
3	Парламент	1	6	6 цаг 11 минут	-
4	Соён гэгээрүүлэгч	7	13	22 цаг 51 минут	-
5	ТВ9	1	-	45 минут	-
6	25-р суваг	1	-	58 минут	-
	Нийт	43	42	128 цаг	

ТЕЛЕВИЗ ТУС БҮРИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛГИЙН НИЙТ ЦАГТ ЭЗЛЭХ ХУВЬ



TenGer болон ТВ8 телевизүүдийн мэтгэлцээний нэвтрүүлэг нь бүрэн дохионы хэлмэрчтэйгээр нэвтрүүлсэн нь нийт 97 цаг 15 мин болж байгаа нь нийт мэтгэлцээний нэвтрүүлэгт 76%-ийг эзэлж байна.

Дээрх 6 телевизээр давталтын дугааруудын хамт 85 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэг бэлтгэн нийт 128 цаг болсон байна. Эдгээр мэтгэлцээний нэвтрүүлэгт 17 нам, 2 эвсэл, бие даан нэр дэвшигч зэрэг давхардсан тоогоор нийт 204 нэр дэвшигч оролцжээ.

МЭТГЭЛЦЭЭНД ОРОЛЦОГЧИД НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААГЧИЙН ТООГООР


№	Нам, эвсэл, бие даагч	25-р суваг	TenGer	Парламент	Соён гэгээрүүлэгч	ТВ8	ТВ9	Нийт /нам, эвслээр/
1	Хөдөлмөрийн үндэсний нам		20		3	7		30
2	Ардчилсан нам		19	1		6		26
3	Монгол ардын нам		20	1		4		25
4	Шинэ Нэгдсэн эвсэл		8		7	6	1	22
5	Иргэний зориг ногоон нам		7		4	4	1	16
6	Үндэсний эвсэл		13			3		16
7	Монголын хүний төлөө нам	1	4			7	1	13
8	Үнэн ба Зөв нам		5		3	2		10
9	Иргэдийн оролцооны нэгдэл нам		2		3	3		8
10	Монголын социал демократ нам		6					6
11	Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам	1	3			1	1	6
12	Бүгд Найрамдах Нам	1	1			3		5
13	Монгол Консерватив Нам		2		1	1		4
14	Ард түмний олонхын засаглал нам		2		1			3
15	Ард түмний хүч нам		2			1		3
16	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам		2					2
17	Эрх чөлөөний эвсэл нам		1			1		2
18	Иргэний хөдөлгөөний нам				1			1
19	Эх орон нам		1					1
20	Бие даагч	1	2		2			5
Нийт		4	120	2	25	49	4	204

Мэтгэлцээнд ХҮН намаас нэр дэвшигчид хамгийн олон буюу 30 удаа оролцсон бол Иргэний хөдөлгөөний нам, Эх орон намын төлөөллүүд тус бүр 1 удаа мэтгэлцээнд оролцжээ. Бие даагчдаас 3 нэр дэвшигч нийт 5 удаагийн мэтгэлцээнд оролцсон байна. Эдгээр 6 телевизийн

бэлтгэн нэвтрүүлсэн мэтгэлцээнд Монголын хүний төлөө намаас нэр дэвшигч Х.Бат-Ялалт 6 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэгт орсон нь хамгийн олон удаа мэтгэлцээнд оролцсон үзүүлэлттэй байна.

МЭТГЭЛЦЭЭНД ОРОЛЦОГЧИД НАМ, ЭВСЛЭЭР

(телевиз тус бүрээр)



TenGer телевизийн мэтгэлцээнд ХҮН болон Монгол ардын намаас нэр дэвшигчид хамгийн олон буюу 20 удаа оролцжээ.

СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ, СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Хамрах хугацаа: 6-р сарын 10-28-ны өдрүүд

Сонгуулийн сурталчилгааны болон санал хураалтын өдөр буюу 6-р сарын 10-28-ны өдрүүдэд нийт 10 телевизээр 237 удаагийн 56 цаг 24 минутын Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлсэн байна. Үүний 123 удаагийн буюу 16 цаг 38 минутын нэвтрүүлэг нь дохионы хэлмэртэй байна. Үүнийг телевиз тус бүрээр авч үзвэл:

**ТЕЛЕВИЗҮҮДИЙН СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН
НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ**

№	Телевизийн нэр	Нийт нэвтрүүлсэн тоо	Нийт нэвтрүүлгийн цаг	Дохионы хэлмэрчтэй нэвтрүүлгийн цаг
1	MNB	123	18:39:58	12:01:40
2	MNB Монголын мэдээ	33	4:59:41	2:38:43
3	UBS	1	0:15:16	0:15:16
4	ETB	2	0:59:42	-
5	Ийгл ньюс	21	8:45:20	0:24:12
6	Өлзий ТВ	3	0:52:24	0:11:26
7	Стар ТВ	1	0:49:03	-
8	ТВ8	4	1:07:06	1:07:06
9	ТВ9	9	2:48:08	0:00:00
10	TenGer	40	17:07:57	0:00:00
Нийт		237	56:24:35	16:38:23

MNB, MNB Монголын мэдээ телевизүүдээр бэлтгэн хүргэсэн сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгүүдийн дийлэнхийг нь дохионы хэлмэрчтэй бэлтгэн нэвтрүүлсэн байна. Мөн UBS, Өлзий, Ийгл ньюс, ТВ8 телевизүүдээр нэвтрүүлсэн 8 удаагийн 1 цаг 58 минутын нэвтрүүлэг нь дохионы хэлмэрчтэйгээр нэвтрүүлсэн байна.

Түүнчлэн сонгогчдын боловсролд зориулсан сурталчилгааг 45 телевиз нэвтрүүлсэн нь нийт 5866 удаа 142 цаг 20 минутын хугацаа зарцуулжээ. Эдгээр нь бүгд Сонгуулийн ерөнхий хорооноос бэлтгэн телевизүүдэд хүргэсэн 16 төрлийн богино шторк хэлбэрийн сурталчилгаа байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Сонгогчдын боловсролд зориулан бэлтгэсэн энэхүү 12 төрлийн сурталчилгааны 13 нь дохионы хэлтэй, 9 нь бичгэн тайлбартай бол 7 нь дохионы хэл болон бичгэн тайлбартай байна.

**ТЕЛЕВИЗҮҮДИЙН СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН
СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ**

№	ТВ нэр	Нийт	Дохионы хэлтэй	Бичгэн тайлбартай	
				Бүтэн	Хагас
1	Гандан ТВ	9:57:35	8:08:14	0:03:52	5:52:49
2	UBS	8:35:46	7:35:27	0:13:38	4:03:51
3	ТВ8	7:40:52	6:41:44	0:18:44	2:58:26
4	Тэнгэр ТВ	7:40:45	5:46:41	-	4:13:23
5	National times news	6:40:03	5:52:49	0:11:47	2:29:56
6	Өлзий ТВ	5:40:56	5:27:37	-	3:04:25

7	Сүлд	5:36:32	2:29:27	-	4:24:06
8	Суваг 1	4:55:08	4:25:30	-	2:19:48
9	SBN	4:37:41	3:18:36	0:05:51	3:03:13
10	Мянгат Малчин ТВ	4:32:03	4:04:11	-	2:26:59
11	ТВ2	4:25:53	3:26:56	-	2:48:14
12	ТМ	4:23:14	3:47:51	0:14:36	2:15:45
13	ЕТВ	4:18:31	3:51:57	-	3:15:37
14	25-р суваг	3:48:22	3:11:30	-	2:02:46
15	MNC	3:39:56	3:39:56	0:04:52	1:37:32
16	Bloomberg MN	3:38:53	3:38:53	-	1:24:18
17	Эко	3:26:58	3:21:04	0:06:50	1:23:34
18	ТВ3	3:25:54	2:32:30	-	1:37:54
19	Ийгл ньюс	3:21:14	2:59:05	0:04:53	1:29:33
20	Малчин ТВ	3:08:30	3:08:30	-	1:49:51
21	Масс ТВ	2:54:44	2:54:44	-	2:13:51
22	Парламент	2:47:26	1:15:16	-	2:00:59
23	NTV	2:44:41	2:24:02	0:04:51	1:15:10
24	ТВ5	2:25:30	2:25:30	0:00:58	0:44:31
25	ТВ9	2:22:27	1:50:03	-	1:29:38
26	MNB	2:21:16	2:21:16	-	1:58:41
27	Лайк ТВ	2:18:30	1:10:48	-	1:07:42
28	Premier 1	2:15:19	2:03:33	-	1:50:07
29	Стар ТВ	2:13:20	2:03:05	-	0:44:55
30	ТВ6	2:12:45	2:05:23	-	1:20:53
31	Channel 11	2:05:27	1:39:03	0:06:48	0:41:11
32	Суваг 7	1:52:22	1:52:22	-	1:14:35
33	News Channel	1:47:29	1:47:29	-	0:47:19
34	C1	1:42:28	1:33:37	-	0:54:31

35	Боловсрол суваг	1:39:24	1:37:56	-	0:35:12
36	MNB Монголын мэдээ	1:24:11	1:19:30	0:04:41	1:16:56
37	Монгол HD	1:01:06	0:50:29	0:03:52	0:11:50
38	ОНТВ	0:36:12	0:36:12	-	0:10:23
39	Хөх Монгол	0:35:42	0:16:12	-	0:19:30
40	Premier 2	0:29:30	0:29:30	-	-
41	Авто ТВ	0:19:17	0:19:17	-	-
42	Premier 4	0:12:54	0:12:54	-	-
43	Premier 3	0:12:42	0:12:42	-	0:06:34
44	Лайв ТВ	0:09:06	0:09:06	0:06:42	-
45	MNB Гэр бүл	0:01:29	-	-	0:01:29
Нийт		142:20:03	120:58:27	1:52:55	75:47:57

Дохионы хэл болон бичгэн тайлбартай 7 төрлийн шторкийг 39 телевизээр 2237 удаа 56 цаг 49 минут нэвтрүүлсэн байна.

**Орон нутгийн телевизүүд сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг,
сурталчилгаа нэвтрүүлсэн байдал**

№	ТВ нэр	Нийт	Дохионы хэлтэй
1	Хэнтий - Өндөрхаан	30:59:37	22:32:40
2	Орхон - ErTV	19:23:05	17:12:49
3	Ховд - Ховд	13:29:48	9:23:18
4	Баянхонгор - Номгон	10:21:19	4:12:04
5	Орхон - Эрдэнэт ТВ	8:35:12	6:14:39
6	Ховд - Олон ястан	8:07:26	7:48:55
7	Орхон - Тусгал 1	8:03:52	7:19:50
8	Төв-TBS	7:31:49	7:31:49
9	Ховд - Жаргалант	6:25:42	4:24:10

10	Архангай - АВТВ	6:22:22	2:04:11
11	Дорнод - Мижи	6:10:48	5:44:06
12	Сүхбаатар - SB	5:29:45	5:13:28
13	Хөвсгөл - Хөвсгөл	4:56:36	4:38:42
14	Өмнөговь - UCTV	4:30:42	4:08:14
15	Дорнод - Д1 ТВ	4:28:31	4:28:31
16	Орхон - NBTB	4:18:45	3:37:38
17	Увс - Сама	4:12:52	4:05:36
18	Орхон - EBS	3:53:24	3:36:57
19	Дорноговь - DTV	3:03:49	2:16:55
20	Орхон - Мэдээллийн Бирж	2:50:33	2:50:33
21	Архангай - Тамир	2:41:05	2:41:05
22	Дорнод - Дорнод	2:39:51	2:39:51
23	Увс-МВС	2:36:06	1:50:05
24	Дархан-Уул- RGB	2:14:29	1:54:39
25	Дорнод - Дорнод ТВ-6	2:06:58	2:06:58
26	Булган - Сайхан Монгол	1:38:05	1:38:05
27	Дархан-Уул - DBS	1:26:22	1:26:22
28	Дархан-Уул - ТВ4	1:18:18	0:39:44
29	Дорноговь - DSB	0:14:38	0:07:12
30	Өвөрхангай - Хас ТВ	1:22:32	1:22:32
31	Орхон - ТВ24	0:48:13	0:46:44
32	Өмнөговь - Алтан говь	0:04:59	0:04:59
Нийт		182:27:33	146:43:21

Дохионы хэл болон бичгэн тайлбартай 18 төрлийн шторкийг 32 телевизээр 6602 удаа 182 цаг 27 минут нэвтрүүлсэн байна.

--oOo--